



Байгалийн нөөцийн хариуцлагатай засаглал




НҮБ-ын Хүнс, Хөдөө Аж Ахуйн Байгууллагаас хэрэгжүүлж буй “Үндэсний хүнсний аюулгүй байдлыг хангах хүрээнд газар, загас, ойн нөөцийн эдэлбэрийн хариуцлагатай засаглалын сайн дурын зөвлөмж”-ийг түгээн дэлгэрүүлэх ажлын хүрээнд Хүн Төвтэй Байгаль Хамгаалал ТББ-аас эрхлэн гаргав.

Нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:
Lkham5@yahoo.com, nyansanjav@yahoo.com








Хариуцлагатай
засаглал гэнэ үү?

Тийм сайн засаглал гэсэн үг.
Байгалийн нөөцийн хүртээмжийг
алагчлалгүй, эрх тэгш болгохыг
зорьдог, жирийн иргэдийг
хамгаалдаг тийм засаглал юм.




Сайн дурын
зөвлөмж
гэнэ үү?

Аан тийм,
Эдэлбэрийн сайн
засаглалыг цогцлоохын
тулд ямар чиг шугам
барихыг төрд зөвлөсөн
олон улсын гарын
авлага юмаа.

Тэгээд
маньд
хамаатай
эд үү?

Хамаатай, хамгийн
их хамаатай,
жирийн хүмүүс бид
чинь эрхээ мэдэж
байх ёстой.



За хө, маньд
хамаатай бол
жаал сонсдог
хэрэг.

Ялангуяа нийгмийн тэгш
эрх, тэр дундаа эмзэг бүлэг,
ядуу дорой хүмүүсийн эрхийг
хэрхэн хамгаалах тухай
ярьж байгаа юм.

ЭНЭХҮҮ ЗӨВЛӨМЖ МААНЬ 7 БҮЛЭГ 26 ХЭСЭГТЭЙ:

1. Эхлэл
2. Нийтлэг үндэслэл
3. Эдэлбэрийн эрх, үүргийн хуваарилалт ба хуулийн зохицуулалт
4. Эдэлбэрийн эрх, үүргийг шилжүүлэх болон бусад өөрчлөлтүүд
5. Эдэлбэрийн удирдлага
6. Уур амьсгалын өөрчлөлт болон онцгой байдлын үед авах арга хэмжээ
7. Сурталчилгаа, хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээ

За хө!


За үндсэндээ бид нэгдүгээр бүлгийг сая жаал ярьчихлаа, Зөвлөмж ямар зорилготой гэх мэт. Гэхдээ эхлээд ганц хоёр үг хэллэгийн утгыг мэдээд авбал уншиж ойлгоход дөхөм болно. Энд зүй ёсны эдэлбэрийн эрх гэж их ярьж байгаа. Үүнд хүнд хуулиар олгосон болон уламжлалт, мөн албан болон албан бус эдэлбэрийн эрх бүгдийг хэлж байгаа юм.

Байз байз, манайх өвөлжөөнийхөө гэрчилгээгээ авч амжаагүй л байгаа. Энэ ямар эрх вэ?

Та олон үеэрээ тэндээ амьдарч ирсэн бол уламжлалт эрх гэж хэлж болно шүү дээ.

Аан, тэгвэл манай эхнэр хөөцөлдөж байгаад өвөлжөөнийхөө эзэмших гэрчилгээтэй болсон.



Тэр чинь таны хуулиар олгосон эдэлбэрийн эрх юм.



Дараа нь 3Б-гийн хэрэгжилтийн 10 зарчим гэж бий.

1. Хүний халдашгүй нэр төрийг хүндэтгэх;
2. Хэнийг ч алагчлахгүй байх;
3. Бүх хүмүүст тэгш эрх ба шударга ёсыг тогтоохын төлөө ажиллах;
4. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ялгааг хүлээн зөвшөөрч хүйсийн эрх тэгш байдлыг хангах, туслах арга хэмжээ авах;
5. Байгаль дэлхийн бүх юмс харилцан шүтэлцээтэй тул нөөц ашиглалтын удирдлагын цогц, тууштай чиг шугамыг баримтлана;
6. Бүгдээрээ хэлэлцвэл буруугүй бүлээн усаар угаавал хиргүй гэдэг шиг зөвлөгөөн, оролцоог хангах;
7. За төрөх үнэн үхэх үнэн гэдэг шиг хууль дүрэмд захирагдах, дотоодын хуулийн хүрээнд, аан мөн олон улсад хүлээсэн үүргийнхээ хүрээнд;
8. Бодлого, хууль, дүрэм журам, гарсан шийдвэрийг ойлгомжтойгоор бичиж, зохих ёсны хэлээр нийтэд мэдээлж ил тод байдлыг хангах;
9. Хариуцлагатай байдал: Хувь хүмүүс, төрийн болон бусад талууд өөрсдийн гаргаж буй үйлдэл, шийдвэртээ хуулийн өмнө хариуцлага хүлээдэг байх;
10. Байнга боловсронгуй болгох: Төрөөс бодит баримтанд тулгуурласан хөтөлбөр боловсруулж цаашид улам бүр сайжруулах.







*Төрөөс хүмүүсийг зохисгүйгээр
албадан нүүлгэхээс сэргийлэх,
эрх нь цуцлагдахаас сэргийлэх
хэрэгтэй гэж байгаа юм.*



*За зөв дөө,
тийм байлгүй
дээ.*



*Мөн жишээ нь төрөөс гэрлэлтийн
байдал өөрчлөгдсөн зэргээс
шалтгаалан сул дорой, мөнгө
төгрөгөөр гачигдаж байгаатай нь
холбогдуулаад ялгаварлан
гадуурхахгүй байх арга хэмжээ
авах хэрэгтэй.*

*Тухайлбал, төрөөс эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн эдэлбэрийн
тэгш эрхийг хангаж, эдгээр эрхийг өвлүүлэн шилжүүлэх,
гэрээслэн үлдээх эрхийг хангах үүрэгтэй гэжээ.
Мөн эрхээ эдэлж, хамгаалж чадахгүй хүмүүст төрөөс
туслахыг зорих хэрэгтэй гэсэн байна.*



Хүмүүсийн газар, загас, ойн нөөцтэй холбоотой эрхээс гадна улс төр, эдийн засаг, соёлтой холбоотой эрхүүдийг бас хүндэтгэн үзнэ гэсэн байна.

Ялангуяа тариаланчид, уугуул иргэд, загасчид, мал аж ахуй эрхлэгчид болон хөдөө ажилладаг хүмүүсийн эрхийг хүндэтгэн хамгаална гэсэн байгаа юм.



За манайд загасчид бараг байхгүй дээ.

Олон улсад зориулсан зөвлөмж юм.



Уугуул иргэд гэдэг чинь бидний ярьдаг уугуул, суугуултай адил уу хэ?



Төрөөс ямар нэгэн зөрчлийг шүүхээр шийдвэрлүүлэх боломжоор хангах хэрэгтэй гэсэн байна. Энд мөн бас нөхөн олговор, нөхөн төлбөрийн асуудал яригдаж байгаа. Эрх нь зөрчигдсөн хүний эрхийг сэргээх, учирсан хохирлын арилгах арга хэмжээ авах хэрэгтэй тухай сануулсан байгаа юм. Мөн хөгжлийн бодлого, хууль боловсруулах, хэрэгжүүлэхдээ байгалийн нөөц ашиглагчдын оролцоог дэмжиж, тэдний оролцоог хөхүүлэн дэмжих хэрэгтэй гэжээ.



Өөр, миний ойлгосноор манай улсын бүх малчид уугуул иргэд юм. Уугуул иргэд гэсэн нэр томъёог бид янз бүрээр ойлгодог. Гол нь энэ зөвлөмжид уугуул болон бусад иргэд гэж тодотгосон учир малчдын тухай ярьж байна гэсэн үг.





Төрөөс хийх хэрэгтэй л гээд яриад байна даа та хэд, төр ч бодлого, хуулиа л гаргаж зохицуулах байх даа.

Яг зөв Түмэндэлгэр гуай Зөвлөмж дээр яг тэгж байгаа юм.

Хоёрдугаар бүлгийн тавдугаарт хэсэгт хуулиар баталгаажаагүй байгаа зүй ёсны эрхийг аль болохоор хууль гаргаж хамгаалах хэрэгтэй гэж байгаа юм. За тэгээд тогтолцооны асуудал болохоор эдэлбэрийн системүүд хоорондоо уялдаатай, нэгдмэл удирдлагатай байх хэрэгтэй гэж заасан юм.



Мөн бодлого, хууль журам, эмэгтэйчүүдийн тэгш эрхийг хангах хэрэгтэй гэж байгаа.

За наадах чинь ч харин манай улсад асуудал биш л болов уу, гэхдээ бас анхаарах зүйл бий дээ

Жендерийн мэдрэмж гэсэн шинэ нэр томьёо гардаг болсон шүү. Энэ нь аливаа үйл хэрэгт эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн тэгш эрхийг хангах тухай л ярьж байгаа юм. Оролцоог хангахад хүртэл ийм байх хэрэгтэй гэсэн байна. Бас төр үйлчилгээгээ аль болохоор хүмүүст ойртуулах хэрэгтэй гэсэн байгаа. Оролцоо гэхээр бас төрөөс энэ бодлого, хууль, зохицуулалтын асуудлуудаа шийдэхдээ нөгөө эрдэмтэн мэргэд, хувийн хэвшлийнхэн, иргэний нийгмээ бас оролцуул л гэж энд хэлээд байна. Мөн тэгээд эргэх холбоотой, хянадаг, сайжруулдаг байх хэрэгтэй гэсэн байна. Мөн авилгын асуудал яригдаж байгаа. Авилгаас сэргийлэхийн тулд бүх тогтолцоогоо ил тод байлгах хэрэгтэй гэсэн байна. Мөн томоохон бодлогын хувьд томоохон өөрчлөлт хийхээр бол үндэсний хэмжээнд зөвшилцөх хэрэгтэй.





Аан тэрийг чинь ойлгож байна шүү. Саяхан манайд үндсэн хуулиа өөрчлөх гээд орон даяар л хэлэлцэж зөвшилцөөд бүр жирийн иргэдийг хүртэл ЗГ-ын ордонд уриад хуралдсан юм

6-р хэсэгт харин төрийн үйлчилгээ үзүүлж байгаа хүмүүсээ боломжийн хэрээр чадавхжуулах хэрэгтэй, ингэхдээ жендерийн мэдрэмжтэй ажиллах тал дээр нь сургах хэрэгтэй гэжээ. Төр гадаад, дотоодын хуулийн хүрээнд, алагчлалгүй хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх хэрэгтэй. Аль болох явдал чирэгдлийг багасгаж хэрэгцээгүй заалтуудаа авч хаях хэрэгтэй. Үйлчилгээгээ хүртээмжтэй байлгахын тулд шинэ техник технологийг ашиглах хэрэгтэй гэсэн байна.



Одоо бараг бүх сум интернэттэй болсон шүү. Гоё байна. Бид чинь ажилаа хийхэд урамтай болж байгаа.



Хотын газар, агентлагууд ч нэгдсэн мэдээний бааз байгуулж эхлээд байгаа.



Мөн төрөөс олонд ил байх ёстой мэдээллийг нээлттэй болгож бусад байгууллага, хүмүүс мэдээллээ солилцох орчин бүрдүүлэх хэрэгтэй гэсэн.



Харин тэх, нэг газар очихоор л нэг өөр юм ярьдаг, учир начир нь ойлгогдодгүй шүү.




Алс хол байгаа хүмүүст ч төрийн үйлчилгээг ойртуулах арга хэмжээ авах хэрэгтэй гэсэн байгаа юм.

Явуулын үйлчилгээ бидэн дээр ирээд газрын гэрчилгээг маань гаргаад өгдөг байвал сайхан аа.

Өвөлжөөний гэрчилгээгээ авах гэж ч бас их удаан хөөцөлдсөн шүү.



Харин тийм, энэ зөвлөмжид төрөөс ялангуяа нийгмийн эмзэг бүлэгт эдэлбэрийн эрхээ эдлэх тал дээр нь туслах хэрэгтэй гэдгийг л онцлоод байгаа юм. Бас нэгэн зүйл нь төрөөс ард иргэдийнхээ хэрэгцээ шаардлагыг байнга судалж үйлчилгээгээ сайжруулах хэрэгтэй, иргэдийн санал гомдлыг шийдвэрлэх механизмтэй байх хэрэгтэй гэсэн байна.



Яг үнэн, Жишээ нь, банкныхан санал хүсэлтийн хайрцаг ажиллуулдаг юм байна лээ. Би тэрэнд нь гомдол бичээд орхисон миний араас утасдаад таны гомдлыг ингэж шийдсэн энэ тэр гээд ярьсан. Дараа нь очсон, үйлчилгээ нь үнэхээр сайжирсан байна лээ.



Яг түүн шиг төрийн үйлчилгээ тийм байх хэрэгтэй юм.



Мөн энд эдэлбэртэй холбоотой үйлчилгээ үзүүлдэг мэргэжлийн холбоод, байгууллагуудын зүгээс ёс зүйн хэм хэмжээ тогтоох хэрэгтэй хэрэв ийм холбоод байхгүй бол төрөөс байгуулах нөхцлийг бүрдүүлэх хэрэгтэй гэсэн байна.

Авилгын индексээр газар олголт хамгийн их авилгалд өртсөн салбар гэж гарсан байна лээ шүү.



Нээрээ тийм байна лээ, эрх мэдлээ хэтрүүлэн ашиглахаа л больчихвол.






За одоо
**Гуравдугаар
бүлгийг харья.** Энэ
бүлэг зүй ёсны эдэлбэрийн
эрхийг баталгаажуулах,
газар, загас, ойн нөөцийн
эдэлбэрийн эрхийг
анхлан олгох
тухай юм.




За байз, Өвөө нь
өвөлжөөнийхөө
гэрчилгээг
авчихвал
баталгаатай болж
байгаа биз дээ?



Тийм, та
уламжлалт
эрхээ
баталгаажуулж
байгаа хэрэг.

Харин малын
бэлчээрийн маань энд
тэнд ухаад л байгаа.
Уг нь манайхан л
зусдаг газар юм.



Хэдийгээр бэлчээр
төрийн мэдлийнх ч
гэлээ, та бэлчээр
ашиглах зүй ёсны
эрхтэй. Тиймд төрөөс
таны эрхийг хүндэтгэн
үзэж, хамгаалах
хэрэгтэй.



Манай малчид бэлчээрээ
хамтаар эзэмшдэг,
төрөөс хамтын
эзэмшлийн системийг
хүлээн зөвшөөрч,
хамгаалах хэрэгтэй гэж
зөвлөмжид байгаа.

Хуулиар баталгаажгаагүй зүй ёсны эрхтэй хүмүүсийг
хамгаалах арга хэмжээг төрөөс авах хэрэгтэй юм.

Зүй ёсны бүх эрхийг хамгаалахын тулд эрх бүрийг
тодорхойлоод, эзэмшигчидтэй нь зөвлөгөөн, оролцооны
зарчмын дагуу зөвлөлдөж шийдвэр гаргах хэрэгтэй.
Мөн эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд адил эрх эдлэх нөхцлийг
хангаж, бүртгэнэ. Аль болохоор бүртгэлжүүлэх хэрэгтэй.

Ингэхдээ ядуу болон, эмзэг бүлгийн хүмүүс эрхээ
баталгаажуулахад нь тусалж, эрх зүйн дэмжлэг үзүүлэх
хэрэгтэй. Шинээр эрхээ авч буй хүмүүст эрх үүргийнх
талаар бүрэн мэдээлэл өгнө. Ямар ч нөхцөлд албадан
шилжүүлэхээс зайлсхийх хэрэгтэй гэх мэт олон чухал зүйлс
зөвлөмжид орсон байна.





Энгийн иргэд
биднийхээ эрхийг
хамгаал л гээд
байна даа.


Тийм. Төрийн мэдлийн
нөөцүүдийг хөгжлийнхөө
зорилтод тулгуурлан
ашиглаж, хяналт
тогтооно. Төрийн
мэдлийн газар гэх мэт
нөөц байсан ч түүнийг
ашигладаг эдэлбэрийн
уламжлалт системтэй
иргэдийн зүй ёсны эрхийг
төрөөс хүндэтгэн, хүлээн
зөвшөөрч, хамгаална.

Төрөөс ил тод бүртгэлийн систем бий болгож зүй ёсны бүх
эдэлбэрийн эрхийг бүртгэх хэрэгтэй. Мөн төрийн мэдлийн нөөцийн
талаарх бодлого боловсруулж олон нийтэд өргөнөөр танилцуулж
ил тод байх хэрэгтэй. Төрийн нөөцийн эрхийг шилжүүлэхээр бол
мөн л ил тод байх хэрэгтэй. Нөлөөлөлд өртөх зүй ёсны эрхтэй
хүмүүстэй зөвлөлдөх хэрэгтэй. Төрөөс эдэлбэрийн эрхийг олгож
байгаа хөтөлбөрүүд нь эрэгтэй, эмэгтэй хүмүүст хэрхэн нөлөөлж
байгаа, хүнсний аюулгүй байдалд хэрхэн нөлөөлж байна, мөн
нийгэм, эдийн засаг, байгаль орчинд хэрхэн нөлөөлж байгаа
зэргийг нягтлан үзэж шаардлагатай бол сайжруулах хэрэгтэй
гэж байна.



Аан зөв,
засаглалыг
засаад л
явна гэсэн
үг.

Тийм, энэ бүлэгт
мөн уламжлалт ёсны
эдэлбэрийн системтэй
уугуул болон бусад
иргэдийн тухай орсон.



Төр болон бусад талууд
уугуул болон нутгийн
иргэдийн хувьд газар,
загас, ойн нөөц нь
нийгэм, соёл, шашин
шүтлэг, эдийн засаг,
байгаль орчин, улс
төрийн чухал үнэт зүйл
болохыг ойлгох хэрэгтэй
гээжээ.



Бидэнд
хамаатай
гэсэн үг.

Уугуул болон нутгийн бусад иргэдийн эдэлбэрийн эрхийг хүлээн зөвшөөрч, хамгаалах, баталгаажуулан, мэдээллийг зохих ёсны хэлээр, хүртээмжтэй хүргэх, бодлого бий болгох, ингэхдээ тэдний үнэт зүйлсийг харгалзан үзэх, эмзэг дорой хүмүүсийг идэвхтэй оролцуулна, Мөн тэдний нөөцийг зөвшөөрөлгүй ашиглахгүй, хэрэв тэдний нөөцийг ашиглах төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхээр бол тэдэнтэй илэн далангүй зөвшилцөх хэрэгтэй, тэдэнтэй хамтран ажиллах замаар бодлого боловсруулах, ингэхдээ алагчлалгүй, жендерийн мэдрэмжтэй байна гэжээ.



Аан зөв
хэрэгжилтийн
10 зарчмаа
баримтлана
гэсэн үг.

Тийм. Мөн уугуул болон
нутгийн иргэдийн маргаан,
зөрчлөө шийддэг уламжлалт
аргыг хүндэтгэж үзнэ. Мөн
төр болон бусад талууд
зөвлөгөөн, оролцооны
зарчмаар, эсхүл иргэдээ
чадавхжуулах замаар авилгаас
сэргийлэх хэрэгтэй гэжээ.





Албан бус эдэлбэрийн тухай бас энэ бүлэгт орсон. Албан бус эрхийг хүндэтгэн үзнэ, хүлээн зөвшөөрнө л гэсэн байна лээ дээ.

Тийм, Албан бус эдэлбэрийн эрхийг хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах талаар бодлого гарга, ингэхдээ иргэдийг оролцуулж, жендерийн мэдрэмжтэй, нөлөөлөлд өртсөн хүмүүст мэргэжлийн болон эрх зүйн дэмжлэг үзүүлэх хэрэгтэй. Албан бус эдэлбэр нь өргөн хүрээний шилжилт хөдөлгөөний үед гардаг гэдгийг анхаарч шаардлага хангасан орон байраар хангах хүртэл гадна, дотно хүлээсэн үүргээ биелүүлэх хэрэгтэй гэсэн байна.



Албан бус эдэлбэр гээч нь юу вэ?



Улс орон бүр өөрийнхөөрөө тодорхойлж болно гэсэн байгаа. Манайд бол одоо амьдралын шаардлагаар хот руу дөхөж ирээд бичиг баримтгүй ч хашаа хатгадаг хүмүүсийг хэлж болох байх. Гэхдээ бас энэ зөвлөмжид албан бус эрхийг хуулиар баталгаажуулах боломжгүй бол төрөөс үндэсний болон олон улсын хуулиар хүлээсэн үүргийнхээ дагуу арга хэмжээ авч, албадан нүүлгэхээс зайлсхийсэн арга хэмжээ авах тухай байгаа юм.

Албадан нүүлгэхээс ямар ч тохиолдолд зайлсхийхийг чармайх хэрэгтэй юм байна.





-Одоо зөвлөмжийн дөрөвдүгээр бүлгийг үзье.

Энэ бүлэгт хөрөнгө оруулалт, газар нэгтгэл, эрх сэргээх, дахин хуваарилалтын шинэчлэлүүд болон эрх цуцлалтын улмаас эдэлбэрийн эрх гүйлгээнд орж, зах зээлийн замаар эдэлбэрийн эрх, холбогдох үүргүүдийг шилжүүлэх, дахин олгохтой холбоотой эдэлбэрийн засаглалын асуудлуудыг тусгасан байна.



Юу юу гэнээ?

Эхлээд зарим нэр томъёог тайлбарлая.

Газар нэгтгэл гэдэг бол нэгээс дээш хүний эрхтэй газрыг нэг эзэмшигчийн нэр дээр болгохыг хэлнэ. Улсын чанартай зам барих зорилгоор хэд хэдэн өрхийн хашааны газрын эрхийг цуцалж улс өөрийн мэдэлд авах жишээтэй.



Газрын төвлөрөл гэдэг нь нэг хүн газрыг их хэмжээгээр эрх мэдэлдээ авахыг хэлнэ.

Аан за, эрхээ л шилжүүлэх тухай байх нь дээ.



Төрөөс эдэлбэрийн зах зээлийг зохицуулж нийгмийн эрх ашгийг зохистой бодлого хуулиар дамжуулан хамгаалах хэрэгтэй гэжээ.

Ил тод, үр ашигтай зах зээлийн үйл ажиллагааг хангах, алагчлалгүй, хүртээмжтэй, өрсөлдөөн бус практикаас сэргийлэх бодлого, хууль гаргаж арга хэмжээ авах хэрэгтэй.

Хүртээмжтэй гэхээр?

Захиргааны журмуудаа хялбарчилж ядуус, нэн эмзэг бүлгийн хүмүүст тохиромжтой болгох гэх мэт.

Аан зөв

Төрөөс зах зээлийн арилжаа, үнэлгээний мэдээллийг ил тод бүгдэд хүртээмжтэй байлгаж, хяналт тавина.

Мөн газрын бүртгэлийн найдвартай системтэй болох хэрэгтэй. Энэхүү бүртгэлд нэр нь ороогүй ч эрх нь байгаа эхнэр, нөхөр, гэр бүлийн гишүүд болон бусад хүмүүсийн зүй ёсны эрхийг хамгаалах баталгааг төрөөс бий болгоно. Энэ бүх процессыг авилгаас гадуур хийх хэрэгтэй гэжээ. Зах зээлийн гүйлгээнд жижиг үйлдвэрлэгчдийн эдэлбэрийн эрхийг бас хамгаалах хэрэгтэй гэжээ.

Аан мөн, яагаад жижиг үйлдвэрлэгчдэд анхаарсан юм бол?

Жижиг үйлдвэрлэгчид үндэсний хүнсний аюулгүй байдал, нийгмийн тогтвортой байдалд чухал ач холбогдолтой байдаг байна.

Хөрөнгө оруулалтын тухай бас энэ бүлэгт яригдсан шүү.



Тийм, хариуцлагатай хөрөнгө оруулалт хүнсний аюулгүй байдлыг сайжруулахад ач холбогдолтой гэдгийг талууд хүлээн зөвшөөрөх хэрэгтэй.

Төрөөс нийгэм, эдийн засаг, байгаль орчны томоохон зорилтуудын хүрээнд газар, загас, ойн нөөцийн хариуцлагатай хөрөнгө оруулалтыг дэмжих хэрэгтэй.



Төрийн болон хувийн хөрөнгө оруулалтад жижиг үйлдвэрлэгчдийг харгалзаж үзэх, дэмжих хэрэгтэй гэжээ.

Хариуцлагатай хөрөнгө оруулалт нь ямар ч хохирол учруулахгүй, зүй ёсны эрхийг хүндэтгэх, байгаль орчны хохирлоос сэргийлэх, хүний эрхийг хүндэтгэх хэрэгтэй. Ийм хөрөнгө оруулалтын зорилго нь төрийн хөгжлийн зорилгуудтай нийцтэй байх хэрэгтэй.

Ямар ч асуудалд арван зарчмынхаа дагуу хандах юм байна.



Эдэлбэрийн эрхийн зөвшөөрөгдөх гүйлгээний хэмжээ, хамрах хүрээ, шинж чанар зэрэг асуудлыг зөвлөгөөн, оролцооны зарчимаар тодорхойлж, ил тод дүрэм, журам гаргана.

Төрөөс эдэлбэрийн эрхийн том хэмжээний гүйлгээнээс үүсэж болзошгүй эрсдэлээс хамгаалах баталгаа гаргана. Ингэхийн тулд арилжих газрын зөвшөөрөгдөх дээд хэмжээг тогтоох, хэтэрсэн тохиолдолд их хурлаар батлуулах зэрэг зохицуулалтууд хийж болно. Эдэлбэрийн эрхийн томоохон хэмжээний шилжүүлгэд хүргэхээргүй үйлдвэрлэл, хөрөнгө оруулалтын загваруудыг санал болгоход анхаарна гэжээ.



Мөн төрөөс холбогдох үйл ажиллагааг гадаад, дотоодын хууль дүрмийн дагуу хийх юм байна. Нутгийн иргэдийн нөөцөд нөлөөлөх хөрөнгө оруулалтын төслийг эхлэхээсээ өмнө тэдэнтэй илэн далангүй зөвлөлдөнө.



Энгийн иргэдтэйгээ байнга л зөвлөлдөж байж шийдэх нь байна.



Тийм шүү, хариуцлагатай хөрөнгө оруулалтыг дэмжих нөхцлүүдийг бас л зөвлөгөөн, оролцооны зарчимаар тодорхойлж, түүнд таарсан бодлого, хуулиудыг боловсруулж нийтэд мэдээлэх хэрэгтэй гэсэн.

Тийм байна, төрөөс эдэлбэрийн эрхийн бүх гүйлгээнд хамааралтай хөрөнгө оруулалтын заалтуудыг эрх нь хөндөгдөж болзошгүй талуудтай зөвлөгөөн, оролцооны зарчимаар боловсруулах хэрэгтэй гэнэ. Ингэж талуудын чадавхийг сайжруулж, шаардлагатай бол мэргэжлийн тусалцаа үзүүлэх шаардлагатай гэнэ.



Эдэлбэрийн эрхийн том хэмжээний гүйлгээтэй холбоотой олон заалт байнаа энэ зөвлөмжид.



Тийм шүү, тийм тохиолдолд хөрөнгө оруулалтын үзүүлж болзошгүй нөлөөлөлд урьдчилсан, бие даасан үнэлгээ хийхэд тавигдах шаардлагын заалтуудыг боловсруулах хэрэгтэй.



Их л зүйл байна даа.



Харин тэх, гэрээний талуудын зүгээс хэлэлцээрт оролцож буй холбогдох бүх хүмүүст мэдээлэлтэй оролцох нөхцлийг бүрдүүлнэ. Мэдээллээр хангаж, гэрээ хэлцлийг баримтжуулж, бүгдэд ойлгуулахад анхаарч ажиллана.



Нарийн юмнууд байна аа.



Тийм, Төрийн бус оролцогч талууд, хөрөнгө оруулагчид ч улсын хууль тогтоомжийг хүндэтгэн, бусдын эдэлбэрийн эрх, дүрэм, журмыг хүлээн зөвшөөрч, хүндэтгэх хариуцлага хүлээнэ.



За наадах чинь их чухал зүйл байна.

Төр болон бусад талууд гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийхэд оролцох хэрэгтэй, шаардлагатай бол залруулах арга хэмжээ авах хэрэгтэй.



Энэ бүлгийн газар нэгтгэл, дахин зохион байгуулалтын тухай зүйлс хэрэгтэй санагдсан.

Төрөөс шаардлагатай үед газрыг нэгтгэх, солилцоо хийх, нэгж талбар эзэмшлийг дахин зохион байгуулахдаа сайн дурын арга замыг хайна гэж байгаа. Төрөөс хувийн өмчийн газрыг нийтийн хэрэгцээний дэд бүтэц барихад зориулан газар нэгтгэл, газрын нөөцөд авч, өртөгсдөд нөхөн олговор хэлбэрээр өөр газар олгож болно.




Манай хотын хамаатны хашаа байшингийн газрыг төр авч, оронд нь мөнгөн төлбөр өгөөд төв зам барьсан гэнэ лээ. Бас өөр газар зааж өгсөн байна лээ дээ.



Аан мөн, Олон нэгж талбарт хуваасан фермүүд, ой зардал ихтэй бол газрын нэгтгэл хийж болох нь. Гэхдээ хуваасан явдал нь эрсдлийг бууруулж, таримлын нэр төрлийг олшруулах гээд сайн талтай бол газар нэгтгэлээс татгалзах нь зүйтэй гэжээ. Төрөөс дахин зохион байгуулалт хийхдээ нөлөөлөлд өртөгсдөд баталгаа гаргаж өгөх нь байна. Тэдэнд зохих ёсны хэлээр хангалттай мэдээлэл өгнө. Мэргэжлийн дэм тус үзүүлнэ. Мөн байгаль хамгаалах баталгаа бий болгох хэрэгтэй.



Зохистой үед эрх нь алдагдсан хүмүүсийн эрхийг сэргээж болно, мөн өв залгамжлагчдад нь эрхийг сэргээж болно, боломжгүй бол өөр газар өгөх хэлбэрээр нөхөн олговор шуурхай олгох хэрэгтэй. Ийм арга хэмжээг хэрхэн авах тухай ил тод, жендерийн мэдрэмжтэй бодлого, хууль гаргаж, нийтэд мэдээлнэ гэжээ.



Дахин хуваарилалтын шинэчлэлүүдийг ч яг адил зарчмаар явуулах хэрэгтэй юм байна.

Энд эрх цуцлах ба нөхөн олговор гэсэн гарчиг байна. Төрөөс зөвхөн нийтийн ашиг тусын тулд эрхийг цуцалж болох юм байна. Гэхдээ нийтийн хэрэгцээний гэж юуг хэлж байгаагаа эхлээд хуулиар нарийн тодорхойлсон байна гэнэ.

Тийм шүү, бид чинь эхлээд түүнийг мэдэж байх ёстой.

Тийм, төрийн бүх үйл ажиллагаа хуулийн дагуу, зүй ёсны эдэлбэрийн эрх эзэмшигчдийн ялангуяа эмзэг, дорой хүмүүсийн эрхийг хүндэтгэн үзэж, зайлшгүй хэрэгцээтэй хамгийн бага нөөцийг татан авч, нөхөн олговор олгох хэрэгтэй юм байна. Хэрэгжилтийн зарчмынхаа дагуу ил тод, оролцоотой байхад анхаарна. Нөлөөлөлд өртөх бүх хүнийг тодорхойлж бүх шатанд зөвлөлдөх хэрэгтэй гэсэн байна.





Одоо
тавдугаар
бүлгийг
сөхье.

Үнэлгээ,
юуны
үнэлгээ
юу?

Энэ бүлэгт эдэлбэрийн эрхийн
бүртгэл, үнэлгээ, татвар,
зохицуулалттай орон зайн
төлөвлөлт, эдэлбэртэй холбоотой
маргаан шийдвэрлэлт, хил дамнасан
асуудлуудтай холбоотой газар,
загас, ойн нөөцийн эдэлбэрийн
удирдлага, засаглалын тухай авч
үзнэ.

Нөөцийг үнэлэх
асуудал юм. Газрын
үнэлгээ гэж яривал
илүү ойлгомжтой
бууна даа.

Зохицуулалттай
орон зайн
төлөвлөлт?

Бүс нутгийн
зохицуулалт хийх
төлөвлөгөө гэж
ойлгож байна.

Аан за,
төлөвлөлт.

Төрөөс
эдэлбэрийн
эрхийн
баталгааг
сайжруулах
зорилгоор
эдэлбэрийн
эрхийг бүртгэх
систем
бүрдүүлнэ.

Энэхүү системд эдэлбэрийн эрх, үүрэг, тэдгээрийг эзэмшиж байгаа хүмүүсийн тухай мэдээллийг бүртгэж, боловсруулж, олон нийтэд мэдээлнэ. Тухайн эрх, үүргүүд нь газар, загас, ойн нөөцийн ямар нэгж талбарууд, эзэмшилд хамаатай болохыг олон нийтэд мэдээлнэ. Бүртгэлийг хүртээмжтэй байлгана. Дүрэм, журмаа хялбаршуулж, орон нутагт тохирох технологийг ашиглана. Орон нутагт тохирсон нэгж талбарын орон зайн нарийвчлал хангалттай байх шаардлагатай. Бүртгэлийг орон зайн нэгжүүд болон болон эрх эзэмшигчдээр индексжүүлж, өрсөж буй болон давхардсан эрхүүдийг тодорхойлно.

Нэгж талбар гэж юу вэ ?


Газрын мэргэжлийн үр хэллэг л дээ, газрыг нэгж талбар бүрээр хуваасан байдаг. Нэгж талбар (парсель) гэж хилээр хязгаарлагдсан, ашиглалтын зориулалт адил, эзэмшигч, ашиглагч, өмчлөгч нь нэг, оноосон дугаартай, кадастрт тусгавал зохих эдлэн газар, объект буюу түүний хэсгийг хэлнэ.



Хувийн нууцыг хамгаалах хэдий ч энэ нь авилга болон хууль бус арилжааг илрүүлэх, олон нийтийн хараа хяналтад саад болох ёсгүй. Ер нь бүртгэлийн бүх үйл явцыг ил тод болгох замаар авилгаас сэргийлэх хэрэгтэй.



Нөөцийн үнэлгээний тухай бий. Төрөөс хөрөнгө оруулалт, эрх цуцлах болон татвар ноогдуулалтын хүрээнд бий болсон зах зээлийн үйл ажиллагаа, зээлийн баталгаа, эдэлбэрийн эрхийн арилжаа зэрэг тусгай зориулалтын эдэлбэрийн эрхийн үнэлгээг шударга байдлаар, цаг тухайд нь хийх системүүдийг бий болгох талаар анхаарна.




Үнэлгээний системд нийцэж байгаа бол нийгэм, соёл, шашин, оюун санааны болон байгаль орчны зэрэг зэх зээлийн бус үнэт зүйлсийг тусгахад анхаарна.



Яг зөв, бүх зүйлийг мөнгөөр хэмжиж болохгүй шүү.



Эдэлбэрийн эрхийн үнэлгээ хийхэд ил тод байдлыг дэмжсэн бодлого, хуулиудыг төрөөс гаргах хэрэгтэй. Худалдах үнэ, бусад мэдээллийг бүртгэн, дүн шинжилгээ хийж хүртээмжтэй болгоно. Үнэлгээ хийх үндэсний стандартуудыг бий болгоно. Хэрэгжүүлэгч агентлагууд энэ стандартуудын дагуу үнэлгээний мэдээлэл, дүн шинжилгээг ил тод байлгана. Ингэж ил тод байдлаар дамжуулан авилгаас сэргийлнэ.



Татвар ноогдуулахад анхаарах зүйлс энэ бүлэгт бий. Төр эдэлбэрийн эрхтэй холбоотой татвараар дамжуулан хөгжлийн томоохон зорилтуудыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр болох орлогоо нэмэгдүүлэх эрхтэй. Татвар нь арилжаагаа бүртгүүлэх, борлуулалтынхаа үнийн дүнг мэдээлэх зэргийг дэмжих ёстой. Татварын бүх асуудлыг зохицуулах бодлого, хууль, бүтэц болгохыг хичээх хэрэгтэй. Татварыг зарцуулахдаа үр ашигтай, ил тод байдлаар зарцуулна. Татварын үнэлгээ бодитой байна. Тооцооллыг нээлттэй байлгана. Ил тод байдлыг сайжруулах замаар авилгаас сэргийлнэ.

Авилгаас
сэргийлэхэд ил тод
байх хамгийн чухал
юм.

Зохицуулалттай орон зайн
төлөвлөлт нь ашиглалтыг
хязгаарлаж, эдэлбэрийн
эрхэд нөлөөлж байдаг юм
байна.


Төрөөс ийм төлөвлөлтийг хийхдээ энэхүү зөвлөмжийн зорилтуудыг хангахад дэмжлэг үзүүлэх зорилгоор боловсруулж, хэрэгжилтэд хяналт, шинжилгээ хийнэ. Төлөвлөлтийн талаарх бодлого, хуулиудыг зөвлөгөөн оролцооны аргаар, жендерийн мэдрэмжтэй хийж, нийтэд мэдээлнэ.



МЭДЭЭЛЛИЙН
ХЭРЭГСЭЛ ← ТӨР



Нөөцүүдийн харилцан уялдааг харгалзана. Төрийн, хувийн, нутгийн иргэдийн гэх мэт олон янзын ашиг сонирхлыг харгалзаж ач холбогдлоор нь эрэмбэлж уялдуулна. Бүх эдэлбэрийн эрхийг харгалзаж үзнэ. Орон зайн төлөвлөлтийг хийхдээ олон нийтийг өргөнөөр оролцуулна. Газар, загас, ойн нөөцийн төрөлжсөн, тогтвортой, тухайлбал арго-экологийн аргууд, тогтвортой эрчимжүүлэлт, уур амьсгалын өөрчлөлт болон хүнсний аюулгүй байдлын сорилтуудыг даван туулах асуудлыг багтаасан менежментийг хөгжүүлэхэд онцгой анхаарна.




Агроэкологи гэж мэдэхгүй юм дуулдана даа хө.

Агротехникийн арга нь үнэндээ агроэкологийн арга юм.




Эдэлбэрийн эрхтэй холбоотой маргааныг шийдвэрлэх тухай бас бий.


Хадлангийн талбайгаас болж бусадтай ч гар зөрүүлээд авах нь холгүй болдог. Энэ тухай юм болов уу.



Тийм, төрөөс эдэлбэрийн эрхтэй холбоотой маргааныг шударга, нэр хүндтэй шүүх, захиргааны байгууллагуудар дамжуулан шуурхай, хүртээмжтэй, үр дүнтэй аргаар шийдвэрлэн залруулах боломж олгоно. Эмзэг бүлгийн, сул дорой иргэдэд туслах арга хэмжээ авах хэрэгтэй.



Ядарсан нэгэндээ дэмжиж туслах нь байна.



Хил дамнасан
асуудлуудын
тухай бас
тусгагдсан
байна.

Манайх ч Хятад,
Оростой л хил
дамнасан асуудлын
тухай ярих байх
даа.



Тийм шүү, Гадна, дотны хуулийн
хүрээнд, шилжин суурьшиж байгаа
иргэдийн эдэлбэрийн эрх, амьжиргаа,
хүнсний аюулгүй байдлыг хамгаалах,
хил дамнасан бэлчээр зэрэг нутгийн
иргэдэд нөлөөтэй асуудлууд дээр
хамтран ажиллах нь зүйтэй гэнэ.




Аан за,
ойлгомжтой
болоод ирж
байна.

Зургадугаар бүлэг
бүхэлдээ уур амьсгалын
өөрчлөлт, онцгой
байдлын үед авах арга
хэмжээний тухай юм.

Уур амьсгалын
өөрчлөлт гэж их
яригдах болжээ.
Аргагүй л нүүрлэж
байна даа.



Төрөөс уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллөөс сэргийлж, гэрээ,
хэлцлийнхээ хүрээнд бүх хүмүүсийн зүй ёсны эрхийг хүндэтгэж,
хамгаална гэжээ. Хүмүүс нүүж ирсэн тохиолдолд тэдэнтэй
зөвлөгөөн, оролцоотойгоор стратеги, хөтөлбөр боловсруулж
хэрэгжүүлэхийг төрөөс эрмэлзэнэ.




Мөн байгалийн гамшгийн үед
хэрхэх тухай орсон байна.

Манай орны
нөхцөлд зуд
турхан, ган
гачиг гээд л.




Тийм бас түймрийн аюул ч байдаг шүү.

Онцгой байдлын үед ч эдэлбэрийн эрхийн асуудлыг авч үзнэ. Аливаа эдэлбэрийн эрхийн зохицуулалтын төлөвлөлтөд байгалийн гамшгийн болзошгүй үр дагавраас урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээг тусгаж өгнө, бас харилцан гамшгаас сэргийлэх хөтөлбөрүүддээ эдэлбэрийн асуудлыг тусгасан байх хэрэгтэй гэнэ шүү.



Гамшиг тохиолдсон үед хүмүүст эрхээ нотлох боломж олгохын тулд эрхийн бүртгэлийн мэдээллийг өөр газар байршуулах, гамшгийн үед түр хугацаагаар нүүлгэн шилжүүлэх боломжтой газруудыг тодорхойлж, тухайн нутгийн эдэлбэрийн баталгааг хангах дүрэм, журам боловсруулахыг эрмэлзэнэ.




Сайн харвал хэрэгтэй зүйл их байна.

Энэ бүлэгт газар, загас, ойн эдэлбэртэй холбоотой зөрчлийн асуудлуудын тухай бас тусдаа хэсэг байна.



Сүүлийн үед манай суманд зөрчилтэй асуудлууд их гардаг. Заримдаа газрын даамал бид чинь яах учраа олохоо байдаг юм.



Энэ хэсэг дүрвэгсэд, шилжин суурьшсан хүмүүстэй илүү холбоотой юм байна.

Тийм байна, үүнийг зөвлөмжөөс нарийн дэлгэрүүлж унших шаардлагатай юм байна.

